

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/001/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар Утас:88883317

Цахим хаяг: Erdnebaatara@audit.gov.mn

Аудитын менежер Б.Тэгшдэлгэр Утас: 99089114

Цахим хаяг: Tegshdelqerb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Давааням Утас: 92113932

Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор С.Гансүх Утас: 86479090

Цахим хаяг: Gansukhsa@audit.gov.mn

Аудитор Г.Ичинхорлоо Утас: 88688168

Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Агуулга

Аудитын тайлан баталгаажуулах тушаал	4-5
1. Хараат бус аудиторын дүгнэлт	6-7
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан	8-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
Санхүүгийн тайлангийн тодруулга	13-22
4. Аудитын тайлан	22
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
5. Аудитын илрүүлэлт	25-29
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	29-30
Хавсралт	32-46

ААН	Аж Ахуйн Нэгж
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар
ОНӨҮГ	Орон Нутгийн Өмчит Үйлдвэрийн Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/10

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/52-1 дугаар тушаал, 2023 оны А/102 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх тухай" тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дахь заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү нийцлийн аудитын газар, Хөвсгөл аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2025 оны 9 дүгээр сарын 20-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Л.Төмөрбаатар)-д зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор (Б.Давааням)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Л.ТӨМӨРБААТАР ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.21 № 1/364
танай -ны № -т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн нэгтгэсэн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хөвсгөл аймгийн Засаг даргын хяналтад байдаг Шинэ мөрөн худалдааны төв ХХК-ийн барилгад 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр гал гарч, 4,971.4 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий барилга, байгууламж шатсан бөгөөд галын дүгнэлт гараагүй, хохирлын хэмжээг эцэслэн тогтоогоогүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 3,654.1 сая төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс 2,031.6 сая төгрөгийн 4 алдааг аудитын хугацаанд залруулж, 1,622.5 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь Ерөнхий сайдтай 2024 онд байгуулсан батламж гэрээнд 48 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 84.2 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамруулаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

6725022260

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болх бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		47,840,655.6	81,530,527.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	20,291,861.4	41,547,251.4
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	8,412,034.8	10,653,550.3
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	719,017.0	713,857.3
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	16,217,007.8	26,057,923.3
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	209,259.7	220,176.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	1,991,475.0	2,337,769.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		163,396,956.3	179,904,882.2
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	2,883,862.9	2,483,712.1
37300	Урт хугацаат зээл		2,883,862.9	2,483,712.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	160,513,093.4	177,421,170.1
39200	Биет хөрөнгө		135,265,434.1	151,923,200.6
39300	Биет бус хөрөнгө	13	24,443,705.2	24,592,415.4
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	803,954.1	905,554.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		211,237,611.9	261,435,409.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		29,290,029.4	45,941,187.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	16,229,732.2	31,614,525.6
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	1,212,000.0
41300	Өглөг	17а, 17б	12,953,697.8	24,588,230.5
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	3,276,034.4	5,814,295.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		13,060,297.2	14,326,661.5
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	13,060,297.2	14,326,661.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		181,947,582.5	215,494,222.6
51	Засгийн газрын хувь оролцоо		181,906,931.1	215,453,571.1
51100	Засгийн газрын оруулсан капитал		49,172,227.1	49,824,933.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		42,312,105.0	44,030,990.8
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/		0.0	12,000.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		15,851,915.7	19,520,546.1
51200	Хуримтлагдсан үр дүн		48,604,345.4	76,186,520.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		25,966,337.8	25,878,580.0
52	Хяналтын бус хувь оролцоо		40,651.5	40,651.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		211,237,611.9	261,435,409.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		90,721,244.2	132,846,448.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		27,551,349.1	56,629,825.5
110	Орлогын албан татвар		19,135,000.6	35,126,656.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		19,322,073.5	35,267,892.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-1,187,545.2	-1,523,344.2
1103	ААН-ын орлогын албан татвар		1,000,472.3	1,382,108.3
113	Хөрөнгийн албан татвар		3,486,799.2	3,658,891.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		4,929,549.3	17,844,278.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	53,950,373.8	70,203,586.5
120	Нийтлэг татварын бус орлого		12,813,950.4	16,064,073.0
121	Хөрөнгийн орлого		160,012.3	108,555.1
122	Тусламжийн орлого		0.0	7,312.5
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		40,976,411.1	54,023,645.9

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		9,219,521.2	6,013,036.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	84,138,367.3	102,383,604.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		83,156,535.5	100,611,602.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		75,388,879.9	94,310,267.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		16,923,089.4	26,247,143.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,137,276.5	3,209,044.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		902,974.7	12,343,044.9
2104	Хангамж, бараа материалын зардал		8,388,880.5	6,039,850.4
2105	Нормативт зардал		291,220.7	310,269.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		661,551.6	2,165,520.4
2107	Томилолт, зочны зардал		363,492.7	540,488.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		28,603,527.8	16,898,695.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		17,116,865.9	26,556,210.6
212	ТАТААС		269,165.9	1,324,694.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		7,498,489.8	4,976,640.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		981,831.7	1,772,002.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		6,582,876.9	30,462,843.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		92,167.7	2,916.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,881,672.5	2,769,649.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		4,793,372.2	27,696,110.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,007,626.6	165,007,626.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-401,544.1	-401,544.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,606,082.5	164,606,082.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-246,215.3	-246,215.3
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	11,430,207.1	11,430,207.1
7	Өмчид гарсан өөрчлөлт	1,369,136.0	1,369,136.0
8	Зарласан ногдол ашиг	-5,000.0	-5,000.0
9	Тайлант үеийн үр дүн	4,793,372.2	4,793,372.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,947,582.5	181,947,582.5
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	181,947,582.5	181,947,582.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	203,701.6	396,468.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	182,151,284.2	182,344,051.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-87,757.8	-87,757.8
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	680,798.8	680,798.8
17	Өмчид гарсан өөрчлөлт	5,363,792.8	5,363,792.8
18	Зарласан ногдол ашиг	-502,773.2	-502,773.2
19	Тайлант үеийн үр дүн	27,867,129.4	27,696,110.6
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	215,472,474.1	215,494,222.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		118,809,829.7	162,023,553.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО		26,865,941.5	56,561,232.4
110	Орлогын албан татвар		18,449,988.2	35,126,656.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		19,282,204.2	35,267,892.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-1,187,545.2	-1,523,344.2
1103	ААН-ын орлогын албан татвар		355,329.2	1,382,108.3
113	Хөрөнгийн албан татвар		3,486,424.7	3,658,891.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		4,929,528.5	17,775,685.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		1,289,753.8	2,686,172.2
1181	Газрын төлбөр		969,965.2	912,403.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		2,669,809.5	14,177,109.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		82,515,910.3	98,967,814.8
120	Нийтлэг татварын бус орлого		41,379,486.9	44,837,420.6
121	Хөрөнгийн орлого		160,012.3	106,748.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		40,976,411.1	54,023,645.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		9,427,977.9	6,494,506.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		102,245,009.9	108,789,062.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		102,245,009.9	108,789,062.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		85,101,121.7	103,112,642.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		24,685,607.9	36,422,794.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,567,487.6	5,137,494.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,653,039.6	13,577,207.1
2104	Хангамж, бараа материалын зардал		20,650,421.8	20,892,193.9
2105	Нормативт зардал		301,732.4	321,014.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		586,743.9	2,085,018.0
2107	Томилолт, зочны зардал		340,568.9	537,908.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		24,822,412.4	15,682,209.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		6,493,107.2	8,456,802.7
212	ТАТААС		269,165.9	1,324,694.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		16,874,722.3	4,351,725.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		16,564,819.8	53,234,490.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		13,023,850.8	28,861,848.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		13,023,850.8	28,861,848.4
2200	Дотоод эх үүсвэрээр		13,023,850.8	28,861,848.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-13,023,850.8	-28,861,848.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-3,201,096.2	-3,117,252.3
14	Бусад эх үүсвэр		0.0	1,221,411.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		2,110,554.7	4,113,120.1
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		1,090,541.5	225,544.1
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		339,872.9	21,255,390.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		19,951,988.6	20,291,861.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		20,291,861.4	41,547,251.4

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд түүний харьяа 64 төсвийн байгууллага, 24 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 49 орон нутгийн тусгай сан болон дансууд, 24 сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын аудитад хамрагдсан хэлбэрийг авч үзвэл 68 байгууллагад санал дүгнэлт гаргаж, 91 байгууллагыг түүвэрт хамруулсан, 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Байгууллагын төрөл	Байгууллагын тоо			Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр		
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		Өөрчлөл тгүй	Хязгаар лалттай	Сөрөг
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан.			
Төсвийн шууд захирагч	64	30	34	29	1	-
Төсөл сан, дансууд	49	0	49	0	-	-
Сумдын ТТЗ	24	24	0	24	-	-
ОНӨААН	24	14	10	11	3	-
ДҮН	161	68	93	64	4	-

Аудитад хамрагдсан төсөв захирагчдын 64 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт, 4 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,776.1 сая төгрөгийн 169 зөрчил илэрснээс 290.0 сая төгрөгийн материаллаг, 6,486.1 сая төгрөгийн материаллаг бус зөрчил илэрснийг төсөв захирагчаар ангилан харуулбал дараах байдалтай байна. /Хавсралт №2-оос дэлгэрэнгүй үзнэ үү/ Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар: Аймгийн Засаг даргын харьяа 24 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 388.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 374.9 сая төгрөгийн зөрчилд 20 зөвлөмж хүргүүлж, 13.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар: Аудитаар нийт 113 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг аудитад хамруулж, 83 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 30 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаснаас 1 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 492.9 сая төгрөгийн зөрчил илэрч 486.8 сая төгрөгийн 64 зөрчилд зөвлөмж хүргүүлж, 6.1 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж шийдвэрлэсэн.

Орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Аудитаар нийт 24 орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж, 10 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 14 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж ажилласан байна. Үүнээс Могойн гол ХК, Шинэ мөрөн ХҮТ ХХК, Хөдөөгийн шийдэл ХХК-иудын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт хүргүүлсэн байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 5,566.3 сая төгрөгийн 69 зөрчил илэрч, 4,102.8 сая төгрөгийн 45 зөрчилд зөвлөмж хүргүүлж, 1,420.8 сая төгрөгийн 17 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 42.7 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож шийдвэрлэсэн.

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2024 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар 4 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт хүргүүлсэн. Бусад аудитад хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт хүргүүлсэн байна.

Өөрчлөлттэй санал дүгнэлт авсан байгууллагуудыг харуулбал:

№	Төсөв захирагчийн хэлбэр	Байгууллагын нэр	Санал дүгнэлтийн төрөл
1	ТШЗ	Мөрөн сумын ЗДТГ	Хязгаарлалттай

2	ОНӨҮГ	Шинэ мөрөн ХҮТ ХХК	Хязгаарлалттай
3	ОНӨҮГ	Могойн гол ХК	Хязгаарлалттай
4	ОНӨҮГ	Хөдөөгийн шийдэл ХХК	Хязгаарлалттай

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 3,654.1 сая төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс 2,031.6 сая төгрөгийн 4 алдааг аудитын хугацаанд залруулж, 1,622.5 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 170.9 сая төгрөг, харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 290.0 сая төгрөг, төсвийн гүйцэтгэлийн аудитаар 74.4 сая төгрөг, нийт 535.3 сая төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлсэн нь бидний тогтоосон материаллаг байдлаас бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлтийг Хөвсгөл аймгийн Засаг дарга, аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,724.9 сая төгрөгийн 116 алдаа илэрч, аудитын хугацаанд 7,396.9 сая төгрөгийн 105 алдааг залруулж, 328.0 сая төгрөгийн 11 залруулаагүй алдаанд зөвлөмж хүргүүлсэн.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 2,031.6 сая төгрөгийн 4 алдааг залруулсан. **Үүнд:**

- Мөрөн Хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн тайлангийн үндсэн хөрөнгө дансыг аудит хийсэн тайлангаас 206.5 сая төгрөгөөр, эздийн өмчийн бусад хэсэг дансыг аудит хийсэн тайлангаас 1,730.9 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна.
- Төмөрбулаг сумын хоршоо хөгжүүлэх сангаас байгууллагад олгосон 57.5 сая төгрөгийн зээлийг гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага дансанд бүртгэсэн байна.
- Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг 24.8 сая төгрөгөөр буруу илэрхийлж, тайлагнасан байна.
- Шишгэдийн харгуй ХХК-ийн 11.8 сая төгрөгийн борлуулалтын орлогыг татварын орлого дансанд тайлагнасан байна.

Дээрх алдаанууд нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын 4.2.1-д "Мөр мөрөөр нэгтгэх горимыг баримтална.....", 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 2-т "Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ", 2025 оны А/З дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" 2.4 (б) "санхүүгийн тайланд төсвийн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, нэмэлт тайлбар, тодруулгыг үнэн зөв толилуулна" гэж заасныг тус тус зөрчсөн, Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын явцад залруулсан.

5.2 Төлбөрийн акт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогүй болно.

5.3 Албан шаардлага

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой:

1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй хэрэгжиж дууссан 1,335.8 сая төгрөгийн 55 зураг төсвийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасанд тус тус нийцээгүй, Оршин байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн хөрөнгө оруулалт данс, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө хэсэгт нийт 1,335.8 сая төгрөгийн зураг төсвийг хөрөнгө хүлээж авсан байгууллагатай тулгалт хийж, шилжүүлж, бүртгэх ажлыг зохион байгуулах

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар:

2.1. Илрүүлэлт:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн нийт байгууллага ахмадын сан байгуулж ажиллаагүй зөрчил илэрсэн, Төсвийн ерөнхийлөн захирагч нь ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3-т "аймаг, нийслэлийн Засаг дарга ахмад настныг дэмжих талаар авах арга хэмжээ, зарцуулах төсвийн санал боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, энэ талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах саналыг халамжийн байгууллагад уламжлах," гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.1. Өгсөн зөвлөмж:

Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, харьяа байгууллагуудын ахмадын сан байгуулах ажлыг зохион байгуулж, шийдвэрлэх.

3. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлагын бүртгэлийн талаар:

3.1 Илрүүлэлт:

Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлого болох 115.7 сая төгрөгийг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд нэгтгэхдээ 4.6 сая төгрөгийг зээлийн хүүгийн орлого дансанд, 3.6 сая төгрөгийг хүүгийн орлого дансанд, 70.9 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлого дансанд, 35.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого дансанд тус тус ялгаатай бүртгэсэн, НБББББ-ийг баримталж ажиллаагүй байна. Энэ нь НБББББ-ийн 5.8.2 Орлогын бүртгэлийн горим хэсгийн "Үндсэн бус үйл ажиллагааны орлогод бусдаас авсан хүү, торгууль..... хамаарна" гэж заасныг зөрчсөн, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлогыг үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд тусгахдаа НБББББ-ийг мөрдлөг болгон ажиллах.

4. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжтэй холбоотой:

4.1 Илрүүлэлт:

Шишгэд харгуй ХХК, Эрчим илч түлш ХХК-иуд нь 2024 оны жилийн эцсээр дуусвар болсон санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, аудит хийлгэж баталгаажуулахгүйгээр санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагад хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тус бүр хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд санхүүгийн тайланг аудитын байгууллагад хүргүүлж, аудитад хамруулж байх талаар арга зүйгээр хангаж ажиллах

4.2 Илрүүлэлт:

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлахдаа 6 аж ахуйн нэгжийн зорилтот түвшнийг нийт 2,518.4 сая төгрөгийн алдагдалтай баталсан, гүйцэтгэлээр 11 аж ахуйн нэгж 2,317.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 7 аж ахуйн нэгж анх батлагдсан зорилтот түвшнийг 3,743.8 сая төгрөгөөр хангаж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Захирал дараах эрх, үүрэгтэй: ...үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах..." гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Компанийн зорилтот түвшнийг батлахдаа ашигтай ажиллах бүхий л боломжийг судалж, орлого зардлыг бодитой төлөвлөсөн эсэхэд хяналт хэрэгжүүлж, ашигтай ажиллуулах нэгдсэн бодлого арга зүйгээр хангаж ажиллах нь зүйтэй байна.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	4	2,031.6			4	2,031.6	4	2,031.6				
ТЕЗ дүн	4	2,031.6	-	-	4	2,031.6	4	2,031.6				
Харьяа байгууллагуудын алдаа												
ТТЗ	12	739.1	3	227.0	9	512.1	12	739.1	6	159.2	6	159.2
ТШЗ	51	1,724.5	15	181.8	36	1,870.8	51	1,724.5	5	168.8	5	168.8
ОНТС	5	314.4			5	314.4	5	314.4				
ОНӨХХК	37	4,618.9	7	494.4	30	4,124.5	37	4,618.9				
Харьяа байгууллагын дүн	116	7,724.9	25	903.2	80	6,821.6	105	7,396.9	11	328.0	11	328.0
Дүн	120	9,756.5	25	903.2	84	8,853.2	109	9,428.5	11	328.0	11	328.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	4	1,622.5					4	1,622.5
ТЕЗ дүн	4	1,622.5					4	1,622.5
Харьяа байгууллагуудын зөрчил								
ТТЗ	18	388.6			1	13.9	17	374.7
ТШЗ	28	253.1			4	6.1	24	247.0
ОНӨ ХХК	46	4,728.0	7	42.7	12	1,282.7	27	3,402.6
Дүн	92	5,369.7	7	42.7	17	1,302.7	68	4,024.3
Нийт дүн	96	6,992.2	7	42.7	17	1,302.7	72	5,646.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил-Харьяа байгууллага								
ТШЗ	40	239.8					40	239.8
ТТЗ	3	0.2					3	0.2
ОНӨ ХХК	23	838.3			5	138.1	18	700.2
Дүн	66	1,078.3			5	138.1	61	940.2
Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил-ТЕЗ								
ТЕЗ	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Нийт дүн	67	1,078.3	0	0	5	138.1	62	940.2